

**НИЙСЛЭЛИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР**

Жанжин Д. Сүхбаатарын талбай 7,  
1 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,  
Улаанбаатар хот, 15160 0035  
Утас: (976-11) 32 71 99  
Цахим хуудас: www.ulaanbaatar.mn

2024.05.15 № 03/2743  
танай -ны № -т

**Тодруулгын хариу хүргүүлэх тухай**

Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас зарласан “Телекамерийн нэгдсэн төвийн техник, тоног төхөөрөмж, систем, программ хангамж (Улаанбаатар хот)” НЗДТГ/20240102009 дугаартай тендер шалгаруулалттай холбоотой “Бодь-Электроникс” ХХК-иас 2024 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр ирүүлсэн тодруулгад дараах хариуг хүргүүлж байна.

1.Тус тендерийн “Багц-1” ажлын даалгаврын 18 дугаар хуудасны 17 болон 18 дугаартай бараанд 2 төрлийн ‘Master Access switch 8 порт болон 16 порт’-ын свич гэж заасан бөгөөд тус 2 төрлийн барааны Тоног төхөөрөмжийн нэр болон Техникийн үзүүлэлт хоорондоо зөрүүтэй байгаа тул тоо ширхгийн хувьд зөрүү үүсэхээр байна. Тодруулбал, нэршлээр буюу тоног төхөөрөмжийн нэрийн дагуу бол Master Access switch 8 портын свич 55 ширхгийг санал болгох уу эсвэл Master Access switch 8 портын техникийн үзүүлэлтээр 97 ширхгийг санал болгох уу гэдэг зөрүү үүсэж байна.

Хариулт: “Багц-1”-ийн ажлын даалгаврын 18 дугаар хуудасны 17 дахь төхөөрөмжийн нэр: Master Access switch 8 port 2x1gb, Тоо ширхэг: 55 ширхэг, Техникийн үзүүлэлт: 8x10/100/1000BASE-T, RJ45|2x100/1000BASE-X SFP, -40 to 85°C (-40 to 185°F), DIN-rail Mount or Wall Mount, IP40 Rated Metal Enclosure, Support 6KV Lightning Protection, ESD 15KV, Support ERPS, QoS, VLANs, etc байна.

“Багц-1”-ийн ажлын даалгаврын 18 дугаар хуудасны 18 дахь төхөөрөмжийн нэр: Master Access switch 16 port 2x1gb, Тоо ширхэг: 97 ширхэг, Техникийн үзүүлэлт: 16x10/100/1000Base-T, RJ45|2x100/1000BASE-X SFP, IP30 Rated Metal Enclosure, DIN-rail Mount or Wall Mount, -40 to 75°C (-40 to 167°F), Robust IP30 Aluminum Metal Enclosure for Use in Industrial Environments, Support QoS, SSH, TLS, SSL, DHCP Snooping, etc байна.

2.Тус тендерийн Багц-2 ажлын даалгаврын 5 дахь бараа болох “Сүлжээний хамгаалалтын төхөөрөмж”-ийн техникийн шаардлагад SG-600-A2600 гэх загварын заасан байх ба тус сүлжээний хамгаалалтын төхөөрөмжийн системийн лицензийн хувьд BDL1-A2600-IN12 , BDL1-A2600-IN36 гэх 2 төрлийн лицензийн шаардлага тавьсан байна. Дээрх 2 лицензийн яг аль нь шаардлагатай эсэх;

Хариулт: Сүлжээний хамгаалалтын төхөөрөмж “Теле камерын хяналтын дэд төв”-д ажиллах системүүдийг гадны сүлжээнд холбоход ашиглах бөгөөд техникийн тодорхойлолтод тусгагдсан BDL1-A2600-IN36 лиценз нь шаардлагад нийцнэ.


3.Тус тендерийн Багц-2 ажлын даалгаврын 16 дахь бараанд “Камерын цэгүүдийг нэгтгэх сүлжээний үндсэн төхөөрөмж нь /SFP 24 port свич/” гэж заасан байна. Тус свитч нь ямар үүрэгтэй эсэх, холболтын зураг бий эсэх;

Хариулт: "Теле камерын хяналтын дэд төв"-д байрлах сүлжээний үндсэн төхөөрөмж бөгөөд нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай, аж ахуйн нэгж байгууллагуудын гадна орчинд суурилуулсан теле камерын дүрсийг нэгтгэх үүрэгтэй төхөөрөмж байна. Техникийн тодорхойлолтыг хангасан, үйлдвэрлэгчийн албан ёсны зөвшөөрөлтэй тоног төхөөрөмж байна.

4.Тус тендерийн Багц-2 ажлын даалгаврын 2.2.2 дахь хэсгийн "видео удирдлагын систем VMS" дэх 5 дахь бараа "Storage server"-т Dell брэндийн серверийн шаардлагыг тавьсан байх бөгөөд брэнд тус бүр өөр өөрийн технологийн онцлогоос хамааран CPU, Memory HDD зэрэг нь харилцан адилгүй байдаг тул бид тус сторэйж серверийн аль үзүүлэлтийг голчилж үзэн бүтээгдэхүүн санал болгох эсэхийг тус тус тодорхой болгож, тодруулгын хариуг ирүүлж өгнө үү.

Хариулт: Техникийн тодорхойлолтод тусгагдсан шаардлагыг хангасан байна. Нэг сторэйж серверт 100 хүртэл теле камер холбох бөгөөд бичлэгийн хугацаа 30-аас доошгүй хоног байна. Их хэмжээний өгөгдөлд ажиллах тул CPU, Memory, HDD-ийн үзүүлэлт чухлыг анхаарна уу.

ДАРГА



Л.ХОСБАЯР